



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/БН

Улаанбаатар хот

Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн албан хаагчдын
хоол, унааны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгын Газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8 дугаар зүйлийн 8.2, 8.4 дэх заалт, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1.5, 2.7.7 дахь заалт, Төвийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт, Удирдлагын зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн албан хаагчдад олгох хоол, унааны зардлыг 2026 оны 04 дүгээр сарын 16-ний өдрөөс 10.000 /арван мянга/ төгрөг болгож шинэчлэн тогтоосугай.
2. Албан хаагчдын хоол, унааны мөнгийг ажилласан ажлын өдрөөр тооцож, сар бүр олгохыг Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны Ахлах нягтлан бодогч /Д.Хонгорзул/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн албаны дарга /Б.Мөнхшүр/-д даалгасугай.

ЗАХИРАЛ /*Отгонбаатар*/

Ж.ОТГОНБААТАР

1606060287